



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2019 оны 06 сарын 18 өдөр

Дугаар 266

Улаанбаатар хот

“Буянт-Ухаа спортын ордон” төрийн өмчит үйлдвэрийн  
газрын зохион байгуулалтын бүтэц, албан тушаалын  
жагсаалт, орон тооны дээд хязгаарыг шинэчлэн  
батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9, 18  
дугаар зүйлийн 5 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Буянт-Ухаа спортын ордон” төрийн өмчит үйлдвэрийн газрын орон тооны  
дээд хязгаарыг 33 /гучин гурав/ байхаар тогтоосугай.

2. “Буянт-Ухаа спортын ордон” төрийн өмчит үйлдвэрийн газрын зохион  
байгуулалтын бүтцийг 1 дүгээр, албан тушаалын жагсаалтыг 2 дугаар хавсралтаар  
шинэчлэн баталсугай.

3. “Буянт-Ухаа спортын ордон” төрийн өмчит үйлдвэрийн газрын орон тооны  
дээд хязгаар шинэчлэн батлагдсантай холбогдуулан Хөдөлмөрийн тухай хууль,  
холбогдох журамд нийцүүлэн удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авч  
хэрэгжүүлэхийг захирал Л.Энхбаярт даалгасугай.

4. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Төрийн өмчийн бодлого,  
зохицуулалтын газрын 2018 оны 477 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

5. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бодлого  
төлөвлөлт, удирдлагын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.


ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

 Б.ГАНБАТ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА


 А.АРИУНБОЛД






Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2019 оны ... дугаар сарын ...-ны өдрийн  
... дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт

“БУЯНТ-УХАА СПОРТЫН ОРДОН” ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРГИЙН  
ГАЗРЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ





Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2019 оны .06. дугаар сарын .18.-ний өдрийн  
266 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт



**"БУЯНТ-УХАА СПОРТЫН ОРДОН" ТӨРИЙН ӨМЧИТ  
ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН АЛБАН ТУШААЛЫН ЖАГСААЛТ**

| Д/д                                     | Албан тушаал                                      | Орон тоо  |
|-----------------------------------------|---------------------------------------------------|-----------|
| 1                                       | Захирал                                           | 1         |
| 2                                       | Дэд захирал                                       | 1         |
| <b>Нэг. Захиргаа, санхүүгийн алба</b>   |                                                   |           |
| 3                                       | Албаны дарга                                      | 1         |
| 4                                       | Маркетингийн менежер                              | 1         |
| 5                                       | Борлуулалтын менежер                              | 1         |
| 6                                       | Нарийн бичиг, нярав                               | 1         |
| 7                                       | Ерөнхий нягтлан бодогч                            | 1         |
| 8                                       | Хуульч, хүний нөөц                                | 1         |
| <b>Хоёр. Техникийн алба</b>             |                                                   |           |
| 9                                       | Албаны дарга                                      | 1         |
| 10                                      | Хөдөлмөр, аюулгүй байдал, эрүүл ахуйн мэргэжилтэн | 1         |
| 11                                      | Дулаан хангамжийн инженер                         | 1         |
| 12                                      | Дуу гэрэлтүүлэг, мэдээллийн технологийн техникч   | 1         |
| 13                                      | Компьютер, техник, сүлжээ хариуцсан мэргэжилтэн   | 1         |
| 14                                      | Цахилгааны техникч                                | 2         |
| 15                                      | Сантехникийн техникч                              | 2         |
| 16                                      | Мужаан                                            | 1         |
| 17                                      | Харуул                                            | 3         |
| <b>Гурав. Нийтлэг үйлчилгээний алба</b> |                                                   |           |
| 18                                      | Албаны дарга                                      | 1         |
| 19                                      | Үйлчилгээний ажилтан                              | 3         |
| 20                                      | Үйлчлэгч                                          | 8         |
| <b>НИЙТ</b>                             |                                                   | <b>33</b> |